



Хураангуй

- 2012 онд НҮБ-с Тогтвортой хөгжлийн 17 зорилгыг баталсан;
- Даян дэлхийн тогтвортой хөгжлийг баталгаажуулах;
- Экологийн тэнцвэртэй, эдийн засгийн үр ашигтай, нийгмийн хэрэгцээг хангахуйц бизнес эрхлэх арга замыг сурталчлах;
- Тариалангийн үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломжтой баримтжуулалт, шалгуур үзүүлэлтийн системийг хөгжүүлэх;
- Уур амьсгал, байгал орчин болон байгалийн нөөцийг хамгаалах арга хэмжээнүүдийг экологи, эдийн засаг, нийгмийн асуудалтай уялдуулан хэрэгжүүлэх нь тогтвортой хөгжлийн үнэлгээний үндэс нь юм;
- Олон тооны шалгуур үзүүлэлт бүхий тогтолцоотой хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд зөвшөөрөгдсөн болон баталгаажсан, бодит тоо - өгөгдөл - баримтыг ашиглах;
- Үнэлгээний үр дүн нь тухайн бүтээгдэхүүнийг орон нутгийн түвшинд төдийгүй нэмүү өртгийн бүх сүлжээнд бусдаас ялгаруулж буй онцлог, давуу тал юм.

Хөдөө аж ахуйн тогтвортой байдлын үнэлгээний ач холбогдол ба хэрэглээ

Зорилго

2012 онд НҮБ-ын гишүүн орнууд Тогтвортой хөгжлийн зорилтууд (ТХЗ)-ыг баталсан. Тогтвортой хөгжлийн 17 зорилт нь дэлхий нийтээрээ эдийн засаг, нийгэм, байгаль орчны тэнцвэртэй, тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн бодлогын зорилтууд юм.

Герман-Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй төсөл”-ийг нэрнээс нь харахад энэхүү хамтын ажиллагааны төсөл нь хөдөө аж ахуйн яриа хэлэлцээг өрнүүлэх, зөвлөгөө өгөх, салбарын боловсон хүчнийг чадавхижуулах замаар Монгол Улсын хөдөө аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг дэмжихэд чиглэгдэжээ.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчид өөрсдийн үйл ажиллагаагаа ашигтай, амжилттай эрхлэхэд нөхцөл байдал улам бүр төвөгтэй болж байна. Бизнесийн амжилт нэг талаар удирдлага, ажилчдын үр чадвараас хамаардаг бол нөгөө талаараа салбарын бодлого, зах зээлийн зохицуулалтаас ихээхэн хамааралтай. Түүнчлэн тариалангийн үйлдвэрлэлд байгаль, цаг уурын нөхцөл байдал онцгой нөлөө үзүүлдэг. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх орчин, нөхцөл улам бүр нарийн төвөгтэй болж байгаатай адил, экологи, эдийн засаг болон нийгмийн олон талт хүчин зүйлс хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортойгоор эрхлэхэд нөлөөлж байна.

Тогтвортой хөдөө аж ахуй нь нөөцийг үр ашигтайгаар ашиглах, байгаль орчныг хамгаалах, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлсэн байхад чиглэгдэх ёстой.


Эдгээр шаардлагуудыг хангахын тулд хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчид практикт суурилсан менежментийн тогтолцоог (баримт бичиг, шалгуур үзүүлэлтүүд г.м.) бүрдүүлэх шаардлагатай юм. Энэхүү арга хэрэгслүүдийн тусламжтайгаар тэд үйлдвэрлэлийнхээ үйл явцад тогтвортой хөгжлийн үзүүлэлтүүдээр дүн шинжилгээ хийж, тогтмол сайжруулах боломжтой болно.

Иймээс тариалангийн аж ахуйн нэгжүүдэд мэдээлэл цуглуулахад хялбар, практикт түршигдсэн, тодорхой нөхцөл байдалд тохируулан хэрэглэж болохуйц үйл ажиллагааны тогтвортой байдлыг үнэлэх үнэлгээний арга хэрэгсэл шаардлагатай болж байна.



ИАК Аграр Консалтинг ХХК-нь нь өнгөрсөн хугацаанд ИНЛ буюу Тогтвортой газар тариалангийн хүрээлэнтэй хамтран хөдөө аж ахуйн анхдагч бүтээгдэхүүний тогтвортой байдлыг үнэлэх үнэлгээний аргачлалыг боловсруулсан бөгөөд энэхүү аргачлалыг монголын тариалангийн аж ахуйн нэгжүүдэд нэвтрүүлэх боломжийн талаар Тогтвортой хөдөө аж ахуй төслөөс бидэнтэй холбогдсон болно. Германы зөвлөх үйлчилгээний компаниуд хамтран „Германы тогтвортой газар тариалангийн хүрээлэн“-г (германаар DINAK буюу ГТГТХ) байгуулсан юм. Тус хүрээлэн нь хөдөө аж ахуй, тариалангийн компаниудын менежментийн өгөгдөлд үндэслэн дээрх аргачлалыг ашиглан экологи, эдийн засаг, нийгмийн гол үзүүлэлтүүдийн үнэлгээг

хийдэг байна. Энэхүү аргачлал нь шинжлэх ухааны үндэслэлтэй томъёон дээр тулгуурлан аж ахуйн тогтвортой байдлын түвшинг бодитойгоор тооцоолох боломжийг олгодог болно.



Зураг 1: Тэсвэрлэх чадвар бүхий эргэлтийн эдийн засаг

Тогтвортой байдлын үнэлгээг эхний ээлжинд тухайн аж ахуйн түвшинд хийнэ.

Үнэлгээний үр дүн нь аж ахуйн нэгж нь бизнесээ экологийн хувьд тогтвортой, эдийн засгийн үр ашигтай, нийгмийн чиг баримжаатайгаар хөгжүүлэх чиглэлийг тодорхойлж өгнө. (Зураг 1-г харна уу). Улмаар энэхүү тогтвортой байдлын үнэлгээг шийдвэр гаргагчид хөдөө аж ахуйн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд суурь мэдээлэл болгон ашиглах боломжтой юм.

Монгол орны тариалангийн үйлдвэрлэлд тогтвортой байдлын үнэлгээний ач холбогдол, хэрэглээ

Хөдөө аж ахуйн анхан шатны үйлдвэрлэлийн тогтвортой байдлын зэрэглэлийг тогтоох нь нэг талаасаа хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд, нөгөө талаасаа бүс нутгийн түвшинд тогтвортой хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх боломжийг олгоно. Байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн үр ашигтай, нийгмийн хариуцлагатай байх гэсэн энэхүү тулгуур гурван үзүүлэлтийг үнэлснээр бизнесийн байгууллагууд үйл ажиллагаагаа илүү тогтвортойгоор эрхлэн явуулах үндэслэл бүрдэнэ.



Зураг 2: Тогтвортой хөгжлийн шалгуур үзүүлэлт

Үүний тулд энгийн, хэрэгжихүйц, гэхдээ шинжлэх ухааны хувьд үндэслэлтэй, батлагдахуйц систем буюу тогтолцоо шаардлагатай юм. Германы Тогтвортой газар тариалангийн хүрээлэнгээс энэхүү асуудлын шийдлийг санал болгож байна. Байгаль орчны үзүүлэлтээс эхлээд эдийн засгийн тоон мэдээлэл, нийгмийн үзүүлэлтүүдийг бүгдийг нь хамарсан олон тооны шалгуур үзүүлэлтээр тухайн аж ахуйн нэгж үйлдвэрлэлээ хэр тогтвортой эрхэлж байгааг харуулах боломжтой. (Зураг 2-г харна уу).



Ашигласан аргууд нь шинжлэх ухааны үндэслэлтэй бөгөөд олон жилийн турш туршигдан батлагдсан болно. Тариалангийн үйлдвэрлэлд байгаль, цаг уурын үзүүлж байгааг нөлөөг тогтоох дүн шинжилгээ нь Халле-Виттенбергийн Мартин Лютерийн их сургуулийн судалгааны арга зүйд тулгуурласан болно. Энэхүү судалгааны арга зүйд "REPRO" хэмээх программыг ашигладаг бөгөөд энэхүү программын тусламжтайгаар хөрс, ус, агаар, биологийн олон янз байдал, малын эрүүл мэнд зэргийг цогцоор нь үнэлэх боломжтой юм. Энэхүү программ нь олон төрлийн үзүүлэлтүүд, тэдгээрийн үнэлгээг нэгтгэж чадсанаараа давуу талтай. Энэхүү үнэлгээний систем дээр эдийн засаг болон нийгмийн шалгуур үзүүлэлтүүдийг нэмж оруулсанаар тогтвортой байдлын цогц үнэлгээг хийх боломжтой болсон юм. Шалгуур үзүүлэлтүүдийг сонгоход тэдгээрийн тогтвортой хөгжлийг хэмжиж чадах хэмжүүрээс гадна тэдний давтагдах чанар нь чухал юм. Тооцооллыг үргэлж зардал-ашгийн харьцааг харуулсан, чанартай өгөгдөлд суурилан хийх ёстой. Мэдээж тухайн салбарын бодлого, аж ахуйн нэгжийн менежментийн өөрчлөлт зэрэг хүчин зүйлсийн харгалзан үзэх хэрэгтэй. Анх тавьсан зорилтот хэмжүүр үзүүлэлттэйгээ гарсан үр дүнг харьцуулах бөгөөд үр дүнд тулгуурлан цаашдын үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлно.

Германы Тогтвортой газар тариалангийн хүрээлэнгийн энэхүү үнэлгээний систем нь эхлээд нөхцөл байдлын өгөгдлийг судална. ААН-ийн сүүлийн 3 жилийн санхүүгийн тайланг үнэлэх нь тухайн компанийн төдийгүй тухайн бүс нутгийн сул талуудыг тодорхойлж улмаар байгаль орчин, уур амьсгал, нөөцийг хамгаалахад чиглэсэн бодит арга хэмжээ авч хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлнэ. Бодит тоо, өгөгдөл, баримтад үндэслэн цаашид авах арга хэмжээний талаар тодорхой хувилбаруудыг гаргах боломжтой. Тухайлбал, ялзмагийн шалгуур үзүүлэлтийг тооцон гаргаснаар яаралтай арга хэмжээг цаг тухайд нь авахгүй бол сэлгээгүй олон жилийн тариалалт хөрсний үржил шимийг бууруулж байгааг мэдэх бололцоотой бөгөөд, хөрсний үржил шимийг нэмэгдүүлдэг шинэ таримлуудыг сэлгээнд оруулах гэх мэт шийдвэрүүдийг гаргахад түлхэц үзүүлнэ. Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэхэд хэр зардал гарах, ажилчдын цалин хөлсийг нэмэгдүүлснээр ажиллах хүсэл эрмэлзэл, улмаар ажлын гүйцэтгэлийг нэмэгдүүлэх боломжтой болох юм зэргийг ч мөн тооцоолох боломжтой. Сүүлийн үед уур амьсгалын хувьд ээлтэй байх гэсэн сэдэв бодлогын хүрээнд ихээхэн яригдах болжээ. ААН нь уур амьсгалын хувьд ээлтэй үйл ажиллагаа эрхэлдэг гэдгийг бид ISO 14067 стандартын дагуу хэмжих боломжтой бөгөөд ингэхдээ аж ахуйн нэгжийн технологийн процессийг суурь өгөгдөл болгон ашигладаг. Тухайлбал ААН-ийн ялгаруулж буй хүлэмжийн хийн хэмжээг тухайн ААН-ийн түвшинд нь эсвэл үйлдвэрлэж буй бүтээгдэхүүн тус бүрээр нь тооцон гаргах боломжтой (Жишээ нь: үр тарианы CO₂ -ийн үл мөр г.м.)

Энэхүү тогтвортой байдлын үнэлгээг хийх нь анхдагч бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа ААН-ийн цаашдын хөгжилд чухал үүрэгтэй бөгөөд тухайн аж ахуй нь улмаар бүтээгдэхүүнээ зах зээлд борлуулах, худалдаалах, боловсруулах үйлдвэрүүдтэй холбогдох, санхүүгийн үйлчилгээ авах зэрэг бусад түнш байгууллагуудтай харилцахад чухал үзүүлэлт болдог. Үр дүнг харуулсан эдгээр индексийг ашиглан ААН тухайн салбар, үйлдвэр, бүтээгдэхүүн, тэр ч бүү хэл бүс нутгийнхаа түвшинд бүтээгдэхүүний онцлогоо харуулах боломжтой болох бөгөөд энэ нь эргээд тухайн ААН-д илүү үнэ цэнэ, үнэлэмжийг бий болгох боломжтой. Тухайлбал хэмжээсгүй тоо болох 1 гэдэг нь тухайн ААН дээд зэргийн тогтвортойгоор ажиллаж байгааг илэрхийлнэ. Тогтвортой байдлын хязгаар нь 0.75 байвал, өөрөөр хэлбэл хязгаарын 75%-д хүрсэн тохиолдолд, тухайн ААН тухайн шалгуураар тогтвортой ажиллаж

байгааг харуулна. Үзүүлэлт 0.75-аас доош бол сайжруулах шаардлагатай гэсэн үг. Бүх түвшний шалгуур үзүүлэлтүүдээр дүн шинжилгээ хийснээр үйлдвэрлэлийн аль хэсэг сул, сайжруулах шаардлагатай байгааг тодорхойлох боломжтой. Бизнес эрхлэгч нь зорилтот арга хэмжээг хэрэгжүүлж, технологийн шинэчлэл хийн тогтвортой байдлаа нэмэгдүүлж, ашигт ажиллагаа эсвэл менежментээ сайжруулах боломжтой.

Зөвлөмж

Тогтвортой байдал гэдэг нь улс төр, эдийн засаг, нийгмийн олон давхаргыг бүхэлд нь хамарсан хариуцлага юм. Үүнд хөдөө аж ахуйн анхдагч үйлдвэрлэл хувь нэмрээ оруулж чадна, хувь нэмрээ оруулах ч ёстой. Ирээдүйд үүнийг шаарддаг, бүр хуульчилдаг болно. Тус хүрээлэнгээс санал болгож буй энэхүү тогтвортой байдлын үнэлгээгээр хөдөө аж ахуйн салбарын байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаарх хэлэлцүүлгийг бодитой болгож, авах арга хэмжээний хэрэгцээ, боломжит шийдлүүдийг нийгэм, олон нийтэд харуулах боломжтой болж байна. Учир нь хэмжиж болох бүхий л зүйлийг, өөрчилж болно. Тухайн бүтээгдэхүүн нь экологи, эдийн засаг, нийгмийн хувьд тогтвортой хөгжлийн шалгуур үзүүлэлтүүдийн хангасан гэдэг баталгааг бий болгож, бүтээгдэхүүний үнэ цэнийг илүү нэмэгдүүлэх ажлыг бид үйлдвэрлэгчид, тариаланчдын оролцоотойгоор хийх боломжтой. Энэ нь Монголын тариаланчдын төдийгүй дэлхийн бусад бүх улс оронд чухал сэдэв болоод байна. Хөдөө аж ахуйн салбарт олон жилийн түрш хэрэгжүүлж ирсэн алдаатай бодлого, хөдөө аж ахуйн компаниудын санаачлагагүй, боловсролын чанар хангалтгүй байдаг зэрэг нь энэ салбарынхныг хоцрогдуулж, зүгээр л “хэлгүй” ханган нийлүүлэгчид болгон хувиргажээ. Энэ нь ойрын ирээдүйд хүнс, хөдөө аж ахуйн салбарт бодит сорилт болох төдийгүй бас шинэ боломжуудыг ч нээж өгнө.

Германы Тогтвортой газар тариалангийн хүрээлэнгээс хүнсний бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээнд оролцогч бүх талууд ашиглах боломжтойгоор үүлэнд суурилсан мэдээллийн платформыг бий болгох зорилготой ажиллаж байна. Тогтвортой үйлдвэрлэлийн гэрчилгээ болон үйлдвэрлэгчийн мэдээлэл дээр үндэслэн тухайн бүтээгдэхүүн нь хэрхэн тогтвортойгоор үйлдвэрлэгддэг болохыг нээлттэй, ил тод болгох нь чухал. Хүнсний бүтээгдэхүүний үнийн шошгоны хажууд үнэлгээний оноог ашигласнаар хэрэглэгч тогтвортой үйлдвэрлэлийг дэмжин, худалдан авах шийдвэрээ гаргах боломжтой юм. Үүнийг нийгэм, бодлогын түвшинд хэдийнээсээ л шаарддаг болсон. Ийм маягаар нийт нэмүү өртгийн сүлжээний үр дүнг илтгэсэн ил тод байдал нь урт хугацааны түршид анхдагч үйлдвэрлэгчдийг байр суурийг бэхжүүлж, урьд өмнө нь хэмжиж, тодорхойлох боломжгүй байсан нэмүү өртгийг баталгаажуулахад чухал алхам болно. Үүнийг Монгол улсад ч мөн хэрэгжүүлэх боломжтой.

Хөдөө аж ахуйн бодлогын яриа хэлэлцээг дэмжиж ажиллана гэсэн үндсэн зорилгынхоо хүрээнд төсөл нь энэхүү тогтвортой байдлын үнэлгээний аргачлал шиг олон шинэ нээлт, инновацийг ХБНГУ-аас Монгол улсад нэвтрүүлэх боломж, гарцыг судлах нь нэн чухал юм.

Зохиогч

Катрин Крафт

Газар тариалангийн ААНБ-ыг зөвлөх

k.kraft@iakleipzig.de

ИАК Аграр консалтинг ХХК

Борнаерын гуд. 16

D – 04288 Лэйпциг

Мэдэгдэл: Энэхүү нийтлэлийг “Герман-Монголын хамтын ажиллагааны Тогтвортой хөдөө аж ахуй төсөл”-с эрхлэн нийтлүүлж байгаа бөгөөд энд дурдагдах санал, үр дүн, дүгнэлт, зөвлөмж нь зохиогчийн байр суурийг илэрхийлэх ба Холбооны Хүнс, Хөдөө Аж Ахуйн Яамны (ХХААЯ)-ны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.